



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ”

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН
ТӨЛӨВЛӨЛТ, БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ХОЛБОГДОХ ХУУЛЬ,
ТОГТООМЖИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

Аудитын код: НАГ-2019/06/-НА

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг
2019 оны 04 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
Утас: 70523020 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Аудитор: Б.Уранбилэг
Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn

Т.Мөнхтогтох
Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар _____	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй _____	3
БҮЛЭГ 1	
ОНХС-ийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу хуваарилсан боловч хандивын орлогыг төлөвлөөгүй байна _____	5
БҮЛЭГ 2	
ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад зарим холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байна _____	8
БҮЛЭГ 3	
ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна _____	18
Аудитын дүгнэлт _____	22
Аудитын зөвлөмж _____	23
Холбогдох байгууллагын санал _____	24
Аудитын тайлан баталгаажуулсан тушаал _____	26

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
БИНХ	Багийн Иргэдийн нийтийн хурал
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНО	Олон нийтийн оролцоотой
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
СОНХС	Сумын орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХАА	Санхүү хяналт аудитын алба
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБББ	Хөгжлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШГ	Шууд гэрээ

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/03 тушаалаа батлагдсан “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2019 оны аудитын төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

ОНХС-ийн 2018 оны хөрөнгийн зарцуулалтад хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг ҮАГ-т хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийгдлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй төлөвлөж, зарцуулсан эсэх.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн болон 14 сумын ОНХС-ийн хөрөнгийн 2018 оны үйл ажиллагаа, аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, СТСХ, баг, хорооны ИНХ-ыг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, МУЕА-ын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан, аймаг, сумдын ЗДТГ, СТСХ болон холбогдох хэлтсийн албан тушаалтантай ярилцах, санал асуулга авах, дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөөг тайлантай тулгах, баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, эрхийн актуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”;
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”;
- Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

Аудит хийж гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа хянан удирдаж, аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж, аудитор Б.Уранбилэг, Т.Мөнхтогтох нар 2019 оны 03 сарын 01-ний өдрөөс 04 сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

БҮЛЭГ 1: ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ХУВААРИЛСАН БАЙНА.

1.1 ОНХНС-ийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.

1.1.1 ОНХНС-ийн эх үүсвэрийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэхээр заасан байдаг.

- Импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь;
- Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь;
- Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;
- Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.

Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас 2018 онд Дорноговь аймгийн ОНХС-д 3,275.6 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хуваарилахаар төлөвлөсөн байна. Орлогын шилжүүлгээс хуваарилах дүнг нэр төрлөөр авч үзвэл: /Хүснэгт №1/

Орлогын шилжүүлэг /сая төгрөгөөр/

Хүснэгт №1

Д/д	Утга	Дүн
1	Дотоодын НӨАТ	728.9
2	Газрын тосны НАТ	343.5
3	АМНАТ	1,391.9
4	Дэмжлэг	706.8
5	Урамшуулал	104.6
	Нийт	3,275.6

Үүнээс аймгийн ОНХС-д 50.5 хувь буюу 1,653.8 сая төгрөг, сумдын ОНХС-д 49.5 хувь буюу 1,621.8 сая төгрөг хуваарилахаар төлөвлөсөн байна.

1.1.2 Олон улсад хөгжлийн санг иргэдэд зориулж төлөвлөдөг сайн туршлагыг судалсан зүйл байхгүй байна.

Гадаад улс оронд явж, туршлага судалсан зүйл байхгүй учир ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнг олон улсын сайн жишээтэй харьцуулан гаргах боломжгүй байна гэсэн тайлбарыг ирүүлсэн.

1.1.3 ОНХНС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн дагуу бүрдүүлсэн байна.

Монгол улсын 2018 оны Төсвийн тухай хуулинд олон улсын байгууллага төсөл хөтөлбөрөөс сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал дэмжлэгийг 811.3 сая төгрөгөөр баталсан байна. Үүний 706.8 сая төгрөг нь ОУ-ын төсөл хөтөлбөрөөс олгох санхүүгийн дэмжлэг, 104.5 сая төгрөг нь ОУ-ын төсөл хөтөлбөрийн урамшуулал байна.

1.1.4 ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.

Монгол улсын 2018 оны Төсвийн тухай хуульд заасан ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 3,275.6 сая төгрөг бүрэн олгосон байна.

1.2 Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу бүрдүүлж хуваарилсан байна.

1.2.1 Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу хуваарилсан байна.

Төсвийн тухай хуулиар аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэр нь ОНХНС-аас олгох шилжүүлэг, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгох гадаад дотоодын дэмжлэг тусламж, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого зэргээс бүрдэхээр заасан байдаг.

Аймгийн ОНХС-ийн 2018 оны эх үүсвэрийг 3,505.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүний 3,275.6 сая төгрөг нь нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг, 60.1 сая төгрөг нь өмнөх оны үлдэгдлээс, 170.0 сая төгрөг нь зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэрээс бүрдэхээр төлөвлөсөн байна.

1.2.2 ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрт 3,505.7 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 3,682.0 сая төгрөг төвлөрсөн байна. /Хүснэгт №2/

ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Хүснэгт №2

№	Эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь	Тайлбар
1	ОНХНС-аас олгох	3,275.6	3,275.6	-	100%	ОНХНС-аас олгосон шилжүүлгийн дүн
2	Өмнөх оны зарцуулаагүй үлдэгдэл	60.1	82.6	-22.5	137%	АОНХС-ийн өмнөх оны зарцуулаагүй үлдэгдлийн дүн
3	Хандив дэмжлэг	153.8	153.8	-	100%	“Смарт ойл Монголиа” ХХК
4	Орон нутгийн төсвөөс	170.0	170.0	-	100%	Орон нутгийн төсвийн орлогоос
	Нийт дүн	3,659.5	3,682.0	-22.5	-	-

ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөгөө гүйцэтгэлийг авч үзвэл:

- Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгох гадаад дотоодын дэмжлэг тусламжаар 153.8 сая төгрөг төвлөрсөн.
- Өмнөх оны зарцуулаагүй үлдэгдлээс 60.1 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн, гүйцэтгэлээр 82.6 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь АОНХС-ийн эцсийн үлдэгдэл 22.5 сая төгрөгийг дутуу төлөвлөсөнтэй холбоотой байна.

Аймгийн Засаг дарга “Доншень-Монгол газрын тос” ХХК-тай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээнд заасны дагуу орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор жил бүр 30.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг байна. Уг орлогыг 2018 онд төвлөрүүлээгүй. Учир нь тус компани 499.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 5 дугаар багт 50 хүүхдийн цэцэрлэгийг 2018 оны 12 дугаар сард шинээр ашиглалтад оруулан хүлээлгэн өгсөн байна.

Цаашид аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөж бүрдүүлэхдээ орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор жил бүр тогтмол төвлөрдөг хандив, тусламжийн орлогыг эх үүсвэрт тусган аймгийн ИТХ-аар батлуулах шаардлагатай байна.

1.2.3 Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу хуваарилсан байна.

Сумдын хөгжлийн индекс, хүн амын тоо, нутаг дэвсгэрийн алслалт, орон нутгийн татварын идэвх санаачилга зэргийг харгалзан үзэж сумдад олгох орлогын шилжүүлгийг дараах байдлаар хуваарилсан байна. /Хүснэгт №3/

**Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн
суурь тооцоолол /мян. төг/**

Хүснэгт №3

Д/д	Сум	Суурь мэдээлэл					Сумдад хуваарилагдах суурь тооцооллын нийт дүн
		Нутаг дэвсгэрийн хэмжээ	Хүн амын тоо	Аймаг хүртэлх зай /км/	Алслалтын индекс	Хүн амын тоонд жинлэсэн алслалтын индекс	
1	Айраг	7.4	3.6	124	0.58	2083.2	95,030.8
2	Алтанширээ	7.2	1.3	92	0.43	540.0	70,514.6
3	Даланжаргалан	4.1	2.7	148	0.69	1844.8	70,056.2
4	Дэлгэрэх	4.8	1.9	132	0.61	1136.4	74,613.2
5	Иххэт	4.2	2.0	170	0.79	1612.2	79,490.5
6	Мандах	12.7	1.6	170	0.79	1238.2	86,904.0
7	Өргөн	8.7	1.9	62	0.29	544.7	81,982.3
8	Сайхандулаан	9.5	1.3	97	0.45	582.9	54,517.7
9	Улаанбадрах	11.4	1.4	134	0.62	891.9	74,886.8
10	Хатанбулаг	18.7	2.8	215	1.00	2752.0	143,987.4
11	Хөвсгөл	8.4	1.5	160	0.74	1129.7	77,226.3
12	Эрдэнэ	9.6	2.3	95	0.44	1034.0	83,415.3
13	Сайншанд	2.3	23.2	-	-	0.0	377,221.5
14	Замын-Үүд	0.4	15.7	203	0.94	14825.6	251,956.6
Нийт		109.4	63.1	-	-	30215.7	1,621,803.2

БҮЛЭГ 2: ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ЗАРИМ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

2.1 Иргэдийн саналаар дэмжигдээгүй, холбогдох бодлогын баримт бичигт тусгагдаагүй ажлыг төлөвлөж, ИТХ-аар баталсан байна.

2.1.1 Зарим сумд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, ТАХ-г төлөвлөхдөө холбогдох журмыг баримтлаагүй зөрчил давтагдсаар байна.

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлд тухайн шатны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө урьдчилсан жагсаалт бэлтгэн иргэдээс санал авч хэлэлцүүлэн нэгтгэн эрэмбэлж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлнэ гэж заасан байна.

Мөн журмын 6.4.3 болон Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 2.2-т ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ нь Улсын Их Хурал, Засгийн газар болон тухайн орон нутгаас хөгжлийн талаар баримталж байгаа бодлого, стратеги, түүнтэй холбоотой бусад бичиг баримттай уялдсан байна гэж заажээ.

2018 онд 14 суманд СОНХС-ийн хөрөнгөөр нийт 2272.9 сая төгрөгийн 92 ТАХ-г хэрэгжүүлэхээр батлуулсан байна. Эдгээр ТАХ-ыг иргэдээс санал авч хэлэлцүүлсэн эсэхийг үзэхэд сумдууд иргэдээс батлагдсан маягтын дагуу саналыг авч, багийн ИНХ-аар хэлэлцүүлэн ач холбогдол, санал авсан тоогоор эрэмбэлэн, тогтоолоор баталсан байхад дараах 3 суманд иргэдийн саналаар гарч эрэмбэлэгдээгүй ТАХ хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Сайншанд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Орон сууцны гадна камер суурилуулалт” /7.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/

- Сайншанд сумын 2, 6-р багт ухаалаг худгийн систем угсралтын ажил /16.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Дэлгэрэх сумын “Иргэдийн ёслол хүндэтгэлийн өргөөг засварлах, тохижуулах” /5.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Дэлгэрэх сумын “Мал нядалгааны цэг байгуулах” /19.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Замын-Үүд сумын ОНХС-ийн хөрөнгөөр 13.1 сая төгрөгийн төсөв өртөг бүхий “Цагдаагийн хэлтэст автомашины хурд хэмжигч худалдан авах”

Энэ нь Төсвийн тухай хуулийн 63.1¹, 63.2² заалт болон холбогдох журам, зааврыг зөрчсөн байна.

2018 онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г сумдын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан төлөвлөжээ.

Харин Сайншанд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ТАХ нь сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан ч тухайн оны сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй байна. Үүнд:

- Нийтийн бие засах газрыг цэвэр, бохир усны шугамд холбох /8.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Орон сууцны гадна камер суурилуулах ажил /7.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Сумын дундын эмнэлгийн моргийн хэсгийн засварын ажил /5.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/

Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 3.5-д ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г тухайн шатны ИТХ-аар батлуулахаар хүргүүлэхдээ тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хэрхэн уялдсан талаарх дэлгэрэнгүй тайлбар үндэслэл, иргэдийн хурлаас гарсан санал, тэдгээрийг тусгасан байдал гэсэн мэдээллийг хавсаргана гэж заасан байна. Гэтэл 2018 онд дээрх заалтыг хэрэгжүүлж, заасан баримт мэдээллийг тусгасан сум байхгүй байна.

Дээрх зөрчилд хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах тухай зөвлөмжийг сумын Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв. /Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.1³, 3.1.2⁴-т заасныг хэрэгжүүлж ажиллах/

2.1.2 Аймгийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г журмын дагуу төлөвлөсөн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2018 онд нийт 1,842.1 сая төгрөгийн 5 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. /2017 оноос шилжсэн 1 ажил/

¹ Баг хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулах

² Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны ИНХ-д гарсан саналыг ИНХ хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно

³ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

⁴ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4 дүгээр бүлгийн 4.1-д “ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр болон тухайн орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан байх” гэж заасан байна.

Дээрх ажлууд нь “Хөгжлийн төлөө хамтдаа” аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2016-2020/, Аймгийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө урьдчилсан жагсаалт боловсруулж, сумдын иргэдээр хэлэлцүүлэн эрэмбэлсэн байна.

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр ТАХ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн зарим заалтыг зөрчсөн байна.

2.2.1 Сангийн хөрөнгөөр ТЭЗҮ, зураг төсөвгүй, чиг үүрэгт хамаарахгүй, чанаргүй ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.1⁵-д заасны дагуу зохион байгуулахаар заасан байна.

2018 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 1373.3 сая төгрөгийн 4 ТАХ, 14 суманд 1399.6 сая төгрөгийн төсөвт өртгөөр 87 ТАХ-г төлөвлөн, хэрэгжүүлсэн байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний сонгон шалгаруулалтын журмын хэрэгжилтийг үзэхэд нийт ХАА-ны 7 хувийг НТШ, 29 хувийг ХА, 9 хувийг ОНО, 56 хувийг ШГ байгуулсан байна.



⁵ ОНХС-ийн хөрөнгөөр сум, орон нутагт бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журмын дагуу зохион байгуулна



Сумдад худалдан авах ажиллагааны тендер зарлахдаа tender.gov.mn цахим хуудсанд тендерийн урилгыг нийтэлж, үнийн санал ирүүлэх мэдэгдэл хүргүүлж байгаа хэдий ч оролцогч ирээгүй шалтгаанаар шууд гэрээ байгуулсан байдал нийтлэг байна. Энэ нь алслагдсан сумд болон ТАХ-ний нийт төсөвт өртөг бага байгаатай холбоотой байна гэж холбогдох албан тушаалтнууд тайлбарлаж байна.

2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны явцад дараах зөрчлүүд гарсан байна.

Үүнд:

- **Иххэт** сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 19.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Баян багт иргэний танхим шинээр барих”, 22.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сумын төвийн ундны усны нөөцийг шинээр тогтоолгох” ажлын гүйцэтгэгчдийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй, **Өргөн** сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 19.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж худалдан авах” ажлын үнийн санал ирүүлэх мэдэгдлийг 2 этгээдэд хүргүүлсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 33.2.1⁶-т заасныг зөрчсөн байна.
- **Иххэт** сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 19.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Баян багт иргэний танхим шинээр барих”, **Мандах** сумын ОНХС-ийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 13.9 сая төгрөгийг төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн төвийн бялдаржуулах танхимын засвар”, **Хөвсгөл** сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 13.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Соёлын төвийн тайз завсар”-ын ажлыг ОНО-той гүйцэтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухайн хуулийн 58.3.3-58.3.7, 58.4.3-58.4.8, Сангийн сайдын 2013 оны 39 дугаар тушаалаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмын 2.2, 2013 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.3⁷-т заасныг зөрчсөн байна.

Сангийн сайдын 2012 оны 212 дугаар тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, урамшууллыг зохицуулах журам”-д заасны дагуу тендерийн үнэлгээний хороог 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр аймгийн болон сумдын Засаг дарга нарын захирамжаар томилсон байна.

Төсвийн тухай хуулийн 29.4, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7-д хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байна гэж заасан байна.

⁶ техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэл хүргүүлнэ

⁷ сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн аж ахуйг хамгаалах, сэргээх, гудамж талбайн гэрэлтүүлэг хийх, түүний засвар үйлчилгээ, тохижилт, цэцэрлэгжүүлэлт хийх, явган хүний зам талбай байгуулах, хог цэвэрлэх малжуулах, нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, сумын бэлчээрийн нөхцөл байдлыг сайжруулах, булаг шанд, ундны усны эх, худаг гаргах хамгаалах, бэлчээр хаших зэрэг холбогдох нарийн мэргэшил шаардахгүй энгийн ажлыг ОНО-той зохион байгуулж болно

Гэтэл дараах сумдад дээрх хууль, журмын заалтад нийцээгүй дараах ТАХ-ыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Дэлгэрэх сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Мал угаалгын ванн” , 19.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Мал нядалгааны цэг барих” .
- Мандах сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 44.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Гурван тээг, Сүүж отрын бэлчээрт гүн өрмийн цооног гаргах”
- Хөвсгөл сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Сургуулийн соёлын танхимын өргөтгөлийн барилгын ажил”, “Жавхлант багийн их засвар”, “Соёлын төвийн тайз засвар”
- Иххэт сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 19.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Баян багт иргэний танхим шинээр барих” .
- Замын-Үүд суманд 51.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Гэр хороололд жишиг гудамж байгуулан тохижуулах” ажил;
- Замын-Үүд суманд 5.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хог ангилан ялгаж пресслэх байгууламжийн барилгын засварын ажил”;

Эдгээр ТЭЗҮ-гүй, төсөв тооцоо хийгдээгүй, мэргэжлийн байгууллагын гаргасан батлагдсан зураггүй ТАХ-г тухайн сумын ИТХ нь батлан хэрэгжүүлж байгаа нь чанаргүй, шаардлага хангахгүй, үр ашиггүй хөрөнгө бий болох эрсдэлийг бий болгож байна.

2018 онд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 2761.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 92 ТАХ хэрэгжүүлэхээр гэрээ байгуулснаас 2688.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 86 ТАХ бүрэн хэрэгжиж, 141.5 сая төгрөгийн төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 ТАХ дутуу хэрэгжсэн байна. Дутуу хэрэгжсэн ТАХ нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Сайншанд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 84.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “7-р багт цэцэрлэгт хүрээлэн” барих ажлын гэрээний дуусах хугацаа болоогүй.
- Хөвсгөл сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 27.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “ЕБС-ийн соёлын танхимын их засвар”-ын хугацаа дууссан боловч ажил дуусаагүй, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй.
- Хөвсгөл сумын “ЕБС-ийн соёлын танхимын их засвар”-ын ажил гэрээний хугацаанд дуусаагүй, санхүүжилтийг бүрэн олгоогүй.
- Замын-үүд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 22.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Сүлд багийн 11 дүгээр хэсэгт 225 метр урт авто замыг асфальтбетон хучилттай болгох ажлыг хүлээн авах комиссын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хурлын тэмдэглэлээр “асфальтбетон хучилт хүйтний улиралд чанар муутай хийгдсэнээс шалтгаалан хайрга чулуу нь сугараад байгаа учраас хүлээн авах боломжгүй, гүйцэтгэгч Борхойн зам ХХК өнгөн хучилтыг 2019 оны 05 дугаар 31-ний өдрийн дотор гүйцэтгэх албан бичгийг ирүүлсэн” тул ажлыг дахин хучилт хийсний дараа хүлээн авахаар шийдвэрлэсэн байна.
- Замын-үүд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 51.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Гэр хороололд жишиг гудамж байгуулан тохижуулах ажил ажлыг хүлээн авах комиссын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хурлын тэмдэглэлээр “хашаа болон гэрэлтүүлгийг хийж дуусгасан ногоон байгууламж, хайсан хашааг хавар хийвэл илүү үр дүнтэй” тул ажлыг 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авахаар шийдвэрлэж, нэмэлт гэрээ байгуулсан байна.



Эрдэнэ сумын 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр нийт 25.4 сая төгрөгийн төсөвт өртгөөр Аман ус байр, Ухаа чулуу байруудад “Тоглоомын талбай барих” ажлыг “Тансаг өндөр констракшн” ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн байна. Одоогийн байдлаар Аман ус байрны тоглоомын талбайн хашаа байхгүй, савлуур эвдэрсэн, сагсны шитны самбар хагарсан, сандлын тавцан эвдэрч хэмхэрсэн байна. Мөн Ухаа чулуу байрны сагсны шитны самбар хагарч, бутарсан байдалтай байна.



Айраг сумын 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр 26.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хог зөөврийн машин”-ыг “Тодбаярт” ХХК гүйцэтгэсэн байна. Аудитаар үзэхэд машины эх биеийн төмөр нимгэн, ачааны хэсгийн шал цөмөрсөн, байдалтай байна.



Алтанширээ сумын 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр 7.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Эрүүл мэндийн төвийн гал тогооны зарим тоног төхөөрөмж, эмч нарын үзлэгийн өрөөний зарим хэрэглэл бэлтгэх” ажлыг “Ламдон” ХХК гүйцэтгэсэн байна. Аудитаар үзэхэд тавилгын чанар муу, шарах шүүгээ эвдэрсэн, хоолны сав зэвэрч цоорсон байна.



Мандах сумын 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хогийн цэг хашаажуулах” ажлыг гүйцэтгэсэн байна. Аудитаар ТАХ-ний хэрэгжилтийг техникийн тодорхойлолтод заасан хог шатаах төмөр пийшин бариагүй байхад ажлыг хүлээж авсан байна.



Сайншанд сумын 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр 19.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Гэр хороололд хуучин гэрэлтүүлэг суурилуулах” ажлыг гүйцэтгэсэн байна. Аудитаар техникийн тодорхойлолтод заасны дагуу гүйцэтгэсэн эсэхийг үзэхэд 15 ширхэг гэрлийг суурилуулаагүй, санхүүжилтийг олгосон байна.

Дээрх зөрчилд хөрөнгийг баталгаат хугацаанд дахин засварлуулах, дутуу хөрөнгийг гүйцээж, ашиглалтад хүлээн авах тухай албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Мөн түүнчлэн барилга угсралт, засвар, гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, инженерийн хийцтэй болон гар худаг гаргах зэрэг ажлуудад ил, далд ажлын актыг үйлдээгүй, ажлыг гүйцэтгэж байх үед захиалагч талаас шаардаагүй, гүйцэтгэгч байгууллага хэрэгжүүлээгүй, ажлын хэсэг баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллаагүй зөрчил нийтлэг илэрч байна. Энэ нь Барилга, хот байгуулалтын сайдын 2005 оны 105 дугаар тушаалыг зөрчиж байна.

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйл, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7-д аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний чиг үүргийг тодорхойлсон байна. Гэтэл дараах сумдад зааварт заасан чиг үүрэгт хамаарахгүй болон урсгал зардлын шинжтэй ТАХ-г хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Дэлгэрэх сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 10.0 сая төгрөгийн өртөг бүхий БИНХ-ийн үйл ажиллагаанд зориулан гэр худалдан авсан.*

- Дэлгэрэх сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 20.0 сая төгрөгийн өртөг бүхий “Мал нядалгааны цэг” байгуулсан.
- Иххэт суманд 3.0 сая төгрөгийн төсөв өртөг бүхий “Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, орчны бохирдлыг багасгах” ТАХ-д сумын нохой, муур устгах зардалд зарцуулсан.
- Сайхандулаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 9.2 сая төгрөгийн төсөв өртөг бүхий “Эм эргэлтийн сангийн засвар”-т зарцуулсан.
- Замын-Үүд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 132.9 сая төгрөгийн төсөв өртөг бүхий “1 дүгээр багийн орон сууцнуудын гадна фасад болон дээврийн засварын ажил”-д нийтийн орон сууцны гадна фасадын ажил хийж гүйцэтгэсэн.
- Замын-Үүд сумын ОНХС-ийн хөрөнгөөр 13.1 сая төгрөгийн төсөв өртөг бүхий цагдаагийн хэлтэст автомашины хурд хэмжигч худалдан авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60.3, ОНХС-ийн зааврын 4.3⁹-т заасныг тус тус зөрчиж байна. Иймд дээрх зөрчилд холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2.2 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлийг бүрэн хянаагүйгээс санхүүжилтийг илүү олгосон байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.18-д “Захиалагч барилгын ажлын зардал, ТЭЗҮ, зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт, материалыг үндэслэн шилжүүлнэ” гэж заасан.

Гэтэл зарим сумдад дээрх журмыг хэрэгжүүлээгүй зөрчил илэрч байна. Үүнд:

- Мандах сумын 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хогийн цэг хашаажуулах” ажлын төсөвт захиалагчийн хяналтын зардалд 392.1 мянган төгрөг, “Эрүүл мэндийн төвийн засвар”-ын ажлын төсөвт 239.8 мянган төгрөгийг тусгасан байна. Гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг бүрэн хянаагүйгээс нийт 631.9 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна.
- Иххэт сумын 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Сумын төвийн ундны усны нөөц тогтоох” ажлын төсөвт захиалагчийн хяналтын зардалд 437.7 мянган төгрөгийн тусгасан байтал гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг хянаагүйгээс дээрх дүнгээр санхүүжилтийг илүү олгосон байна.
- Айраг сумын 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Сумын төвд худаг гаргах” ажлын төсөвт захиалагчийн хяналтын зардалд 389.2 мянган төгрөгийн тусгасан байтал гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг хянаагүйгээс дээрх дүнгээр санхүүжилтийг илүү олгосон байна.
- Дэлгэрэх сумын 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Мал угаалгын ванн” барих ажлын гэрээний дүнгээс 33.2 мянган төгрөгийг үндэслэлгүйгээр илүү шилжүүлсэн байна.

Дээрх зөрчилд холбогдох албан тушаалтанд хариуцуулж төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

⁹ Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан ОНХС-аас зарцуулахыг хориглосон зүйлд зарцуулахгүй байх.

Мөн Хөвсгөл аймгийн ОНХС-ийн үйл ажиллагаанд аудит хийхэд 2018 оны ОНХС-ийн баримт материалыг үдэж архивлаагүй, тендерийн баримт бичиг цэгцгүй, техникийн тодорхойлолт олон янз, засварын ажлын төсвөөр барилга байгууламж барьсан, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл байхгүй зэрэг сангийн үйл ажиллагаа хариуцсан ажилтны хариуцлагыг сайжруулах хэрэгтэй байна.

2.2.3 Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 111.6 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын өмчид бүртгээгүй байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.6-Д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ” гэж заасан байна.

Гэтэл Сайншанд сумын 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлж гүйцэтгэсэн дараах ТАХ-ыг НББ-д тусгаагүй байна. Үүнд:

- 8.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Нийтийн бие засах газрыг цэвэр бохир усны шугамд холбох”,
- 18.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сайншанд сумын 1-р баг 32, 33-р байрны гадна талбайн тохижилт”,
- 12.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “5-р багт сагсан бөмбөгийн талбай барих”,
- 10.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Нийтийн эзэмшлийн зам талбайд дэгээтэй бункер нийлүүлэх”,
- 9.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Нийтийн эзэмшлийн зам талбайд жижиг хогийн сав нийлүүлэх”,
- 40.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сайншанд сумын 3-р багт тоглоомын талбай байгуулах”
- 12.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сайншанд сумын 5-р багт сагсан бөмбөгийн талбай барих ажил”

Дээрх ашиглагч байгууллагын өмчид бүртгээгүй 111.6 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгах тухай албан шаардлагыг Сайншанд сумын Засаг даргад хариуцуулан тогтоохоор шийдвэрлэв.

3 БҮЛЭГ: ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТОДОРХОЙ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

3.1 Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба ОНХС-ийн 2018 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй, ИТХ-аас сумдыг бүрэн хамруулаагүй байна.

3.1.1 2018 онд ОНХС-ийн үйл ажиллагаанд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1, 9.3, 9.4-т ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд нийгмийн байгууллагууд, иргэд хяналт тавьж, үнэлгээ хийнэ гэж заасан байна.

2018 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 46 дугаар тогтоолоор аймаг, орон нутгийн хэмжээнд хийгдэж буй улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, бусад эх үүсвэрээр хийгдэж буй хөрөнгө оруулалтын зарим ажлын төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, гүйцэтгэл, санхүүжилт, тэдгээрийн хэрэгжилт, ил тод байдалд хөндлөнгийн хяналт шалгалтыг хурлын хороодын хамтарсан ажлын хэсгээс зохион байгуулсан байна. Ажлын хэсэг Сайншанд, Эрдэнэ, Замын-Үүд сумдын 2017, 2018 онуудад хийгдсэн ТАХ-үүдийг газар дээр нь танилцаж, холбогдох байгууллагуудаас тайлбар тодруулга авч дүгнэлт зөвлөмж боловсруулан ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж аймгийн Засаг даргад үүрэг чиглэл хүргүүлэн ажилласан байна. Үүнд худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, захиалагчийн хяналтыг сайжруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хөрөнгийг бүртгэлд тусгах, хөрөнгө оруулалтын мэдээллийг олон нийтэд мэдээлж байх зэрэг үүрэг чиглэлийг өгсөн байна.

3.1.2 СХАА-аас 4 суманд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилт тайлант онд хангалтгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-д гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг Төсвийн тухай хуулийн 69.1¹⁰-д заасан байгууллага, 14.2.10¹¹ болон Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.2¹²-т заасны дагуу хэрэгжүүлнэ гэж заасан байна.

2018 оны аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2018 оны хяналт, шалгалтын төлөвлөгөө, албаны даргын 08 тоот удирдамжийн дагуу Иххэт, Сайхандулаан, Даланжаргалан, Дэлгэрэх сумдын 2016-2017 оны ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчлөөс дурдвал дараах байдалтай байна. Үүнд:

- Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг хэлэлцэх хурлын зарыг айл өрхүүдэд хүргэсэн эсэх нь тодорхойгүй;
- Иргэдийн оролцооны бүртгэл хөтлөөгүй;
- ИТХ болон иргэний нийгмийн байгууллагаас хяналт тавиагүй;
- Холбогдох маягтыг бүрэн бөглөөгүй;
- ИНХ-ыг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй;
- Магадлашгүй ажлын зардал, техник хяналтын зардалыг илүү олгосон.


Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.5-д “ аймгийн ЗДТГ нь аймаг, сумын ОНХС-ийн хэрэгжилтийг санхүүгийн болон бусад хяналт, шинжилгээ үнэлгээний үзүүлэлтээр мэдээллийн сан байгуулах, мэдээллийн санг холбогдох мэдээллийг тогтмол баяжуулж байх, ...” гэж заасан байна.

¹⁰ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

¹¹ Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх

¹² ОНХС-аас хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ

Сангийн яамны tof.gov.mn хаягаар дамжуулан ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийн төлөвлөлт, бүртгэл, тайлагнах зорилго бүхий УМС болох “Орон нутгийн хөгжлийн сан” гэсэн мэдээллийн сан бүрдүүлэх зорилготой online программыг үүсгэсэн байна. Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн холбогдох мэргэжилтэн ОНХС-ийн мэдээллийн санд мэдээллийг сар, улирал, оруулж, цахим тайланг илгээсэн байна.



3.1.3 Аймаг, сумын захиргааны байгууллагаас олон улсын туршлага судалсан, хөрөнгө оруулалтын ажлыг харьцуулан судалсан тодорхой ажил хийгдээгүй байна.

Аймаг, сумдын захиргааны байгууллага холбогдох албан тушаалтнаас 2018 оны ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилт, түүний үр дүнг олон улсын сайн туршлага, жишээнд харьцуулж, үнэлсэн арга туршлага байгаа эсэхийг асуухад “Гадаад улс оронд туршлага судалсан зүйл байхгүй учир ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилт, үр дүнг олон улсын сайн жишээтэй харьцуулан гаргах боломжгүй байна” гэсэн тайлбарыг өглөө.

3.2 ОНХС-ийн үйл ажиллагааны явцын мэдээг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

3.2.1 ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг аймгийн Засаг дарга томилоогүй байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1¹³, 10.2¹⁴-т заасны дагуу аймгийн ЗДТГ-ын ХОХБХ-ээс ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулж, үнэлгээ дүгнэлт гаргаж, шаардлагатай бол ИТХ-аар хэлэлцүүлэхээр заасан байна.

2018 онд Аймгийн Засаг дарга ОНХС-ийн зааварт заасан үүрэг бүхий ажлын хэсгийг томилоогүй байна. Иймээс ажлын хэсгийн гүйцэтгэх ёстой ОНХС-ийн хэрэгжилтэд дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмжийг боловсруулж шийдвэрлүүлэх ажил хийгдээгүй байна.

¹³ Сум дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст ирүүлнэ. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна.

¹⁴ ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна. Ажлын хэсэг нь ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмжийг сум бүрээр гарган аймгийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар жил бүрийн 2 сарын 25-ны дотор хэлэлцүүлнэ.

Дээрх зөрчилд холбогдох албан тушаалтанд аймгийн ЗДТГ-ын ХОХБХ-ийн журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллуулах тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Мөн ОНХС-ийн зааврын 10.3¹⁵-т заасан тайлан мэдээг хүргүүлсэн эсэхийг үзэхэд аймгийн ЗДТГ-ын ХОХБХ-ээс аймгийн ОНХС, СТСХ-ээс сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна. Харин санал, зөвлөмж боловсруулж хүргүүлээгүй байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.1-д “ ... сумын санхүүгийн алба нь ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ журмын 10 дугаар хавсралтад заасны дагуу аймгийн СТСХ-т Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах хугацаанд тайлагнана” гэж заасан байна.

Дээрх журам заасны дагуу нийт 14 сумаас 2018 оны ОНХС-ийн жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хавсралт маягтаар аймгийн СТСХ-д ирүүлж, мэдээллийн санд мэдээлсэн байна.

3.2.2 Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

ОНХС-ийн 2017 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг үзэхэд дараах байдалтай байна. /Хүснэгт №4/

Өмнөх оны акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн байдал

/сая төгрөг/

/Хүснэгт№4/

Үзүүлэлт	Тогтоосон		Хугацаандаа хэрэгжсэн		Хугацаандаа хэрэгжээгүй		Хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	17	935.7					17	935.7	-
Албан шаардлага	13	526.9	8	294.2	5	232.7			62%
Төлбөрийн акт	5	13	2	10.5			2	2.5	100%
Дүн	35	1475.6	10	304.7	5	232.7	19	938.2	

Өмнөх оны аудит 2018 оны 9-11 сард хийж гүйцэтгэн өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 3, 6 саруудад хэрэгжүүлэхээр хүргүүлсэн байна. Одоогоор хугацаандаа 232.7 сая төгрөгийн албан шаардлага ирүүлээгүй буюу хэрэгжүүлээгүй, 10.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт хугацаандаа хэрэгжсэн байна. Мөн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй байна.

¹⁵ Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайлан, гарсан санал зөвлөмжийн хамт жил бүрийн 3 дугаар сарын 10-ны дотор Сангийн яамны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хэлтэст ирүүлнэ

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу хуваарилж, олгосон байна.
- 2018 онд ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн саналаар дэмжигдээгүй, заасан чиг үүрэгт тусгагдаагүй, ТЭЗҮ, зураг төсөвгүй, ХБББ-тэй уялдаагүй ТАХ-г ИТХ-аар батлуулан хэрэгжүүлсэн байна.
- Захиалагчийн хяналт хангалтгүйгээс ашиглалтын шаардлага хангахгүй, чанаргүй ажлыг хүлээн авсан байна.
- ОНХС-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үйл явцад дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг Аймгийн Засаг дарга томилоогүйгээс сангийн хэрэгжилт, үр дүнд шинжилгээ хийх, санал, зөвлөмжийг гаргах, ИТХ-аар хэлэлцүүлэх зэрэг ажлууд орхигдсон байна.
- Аймаг, сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын ажлаар 2018 оны үйл ажиллагааг бүрэн хамруулаагүй байна.
- Гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн гүйцэтгэлд хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээр захиалагчийн хяналтын зардал, төсөвт өртгөөс санхүүжилт илүү олгох зэрэг зөрчил илэрч байна.
- Сайншанд сум 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 111.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 ТАХ-г ашиглагч байгууллагын бүртгэлд тусгаагүй байна.
- Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж бүрэн хэрэгжих хугацаа болоогүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Т.ЭНХТҮВШИН ТАНАА

1. Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.3-т “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна” гэж заасныг хэрэгжүүлэх.
2. Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4-т заасны дагуу хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

ХӨВСГӨЛ, ИХХЭТ, САЙНШАНД, ДЭЛГЭРЭХ, МАНДАХ, ЗАМЫН-ҮҮД СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

1. Төсвийн тухай хуулийн 29.4, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3-6 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлж ажиллах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон,
Утас/факс: (705) 2-30-03
E-mail: dornogobi_mgl@yahoo.com


2019.04.11 № 3/654

танай 04.10 -ны № 1-6/400 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагын 2019 оны 1-6/400 тоот албан бичгээр ирүүлсэн Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлантай холбоотой санал байхгүй болно.

ДАРГА



Б.ГАНЗОРИГ

44 8 10509

D:\2019\ZAH-TOOT

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Аудитор

Б.Уранбилэг

Аудитор

Т.Мөнхтогтох

ХЯНАСАН:

Аудитын менежерийн үүргийг

түр орлон гүйцэтгэгч

Ц.Лүндэгмаа

Дарга, Тэргүүлэх аудитор

Ч.Ариунаа

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД

ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/09

Дорноговь аймаг, Сайншанд сум

Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйл, 19 дүгээр зүйлийн 19.3.3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаал, Ерөнхий аудиторын 2018 оны А/207 тоот тушаалын 5 дугаар хавсралтын 2.4, "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлага, актыг хавсралтаар баталсугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж үр дүнг 2020 оны 01 дүгээр сарын 15 -ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга болон сумдын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.
4. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумдын Засаг дарга нарт хүргүүлсүгэй.
5. Акт, албан шаардлага, Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Лүндэгмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА